

АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 7.2 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 73.6 хувиар давсан байна.

Онгон, Уулбаян, Баруун-Урт сумдаас бусад сумд төсвийн орлогын төлөвлөгөөгөө давж биелсэн байна. Орон нутгийн төсвийн зарлага 5.7 тэрбум төгрөг болжээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас ААНБ, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 30.3 тэрбум төгрөгт хүрч, 2010 оны жилийн эцсээс 10.7 тэрбум төгрөгөөр буюу 54.8 хувиар өсчээ.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 14.9 тэрбум төгрөг болж, 2010 оны жилийн эцсээс 3.3 тэрбум төгрөгөөр буюу 29.1 хувиар өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Ургац хураалт, хадлан бэлтгэл: 8-р сарын байдлаар аймгийн хэмжээнд 3 сум бага хэмжээний төмс, хүнсний ногоо хураан аваад байна. Үүнд: Асгат, Баяндэлгэр сумд 18.2 тн төмс, Асгат, Баяндэлгэр, Түвшинширээ сумд 6.52 тн хүнсний ногоо тус тус хураан аваад байна.

Өвөлжилтийн ажил сумдад эхлэж байна. Нийтдээ 3.5 мянган тонн өвс, 0.3 мянган тонн гар тэжээлийг сумд бэлтгээд байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 17.7 тэрбум төгрөг болж, борлуулалт 69.5 тэрбум төгрөгт хүрсэн нь урьд оны мөн үеэс нийт бүтээгдэхүүн доогуур, харин борлуулалт дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн буурсан нь Талын гал, Андын элч, Эрдэнийн олз ХХК-нууд үйлдвэрлэлт эрхлээгүйтэй холбоотой байна.

Гол нэр төрлөөс талх, хиам, нүүрс, дулаан үйлдвэрлэлт, замын хавтан, боржуур, блок зэрэг нэмэгдсэн.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 8-р сард 2010 оны эцсийнхээс 1.3 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана хувцас, бөс, бараа, гутлын бүлгийн үнэ 1.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 2.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 2.5 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 6.3 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 7.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 6.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 19.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин согтууруулах бус ундаа, холбооны бүлгийн үнэ тогтвортой байж бусад бүлгийн үнэ 2010 оны жилийн эцсээс буурсан байна.

VI. ЭРҮҮЛ МЭНД: 873 эх амаржиж, 879 хүүхэд төрсөн нь урьд оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 389 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 63-аар олон байгаа бөгөөд мөөгөнцөр, салхицэцэг, тэмбүү, трихоминиаз, заг зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 975 болж, эхний 8 сард 68-аар нэмэгдсэн байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 65.4 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 19.0 хувь нь дээд, 2.3 хувь нь тусгай дунд, 36.0 хувь нь бүрэн дунд, 7.7 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 8 сард 2504 хүн шинээр бүртгүүлж, 2193 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 711 хүн ажиллаж байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: Бүртгэгдсэн гэмт хэрэг 146 байгаа нь урьд оны мөн үеэс дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 32 хүн нас барж, 42 хүн гэмтэж осолдсон нь урьд оны мөн үеэс өссөн байна. ААНБ, иргэдэд 29.4 сая төгрөгийн хохирол учирсны 27.6 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 141 хүн сэжиглэгдсэний 26.2 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 1853 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 227 хүнээр олон байгаа бөгөөд баривчлуулсан хүний тоо урьд оны мөн үеэс дээгүүр байна.



АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС